

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Аудитор М.Атарцэцэг
Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-12
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.МӨНХТУЯА ТАНАА

2022.02.27

№

67

танай

-ны №

-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар ажиллагсдад амралт, цалин давхардуулан олгосон, төлбөрийн актыг төсвөөс төлсөн, аялал зугаалгын зардалд хөрөнгө зарцуулсан, цалингийн нөхөн олговор төсвөөс төлсөн, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан, хууль тогтоомжид заагаагүй албан тушаалтанд тэтгэмж олгосон, батлагдсан бүтэн орон тоогоор ажиллаагүй, засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, гэрээний хугацааны дагуу малыг дараагийн айл өрхөд шилжүүлээгүй зэрэг 118.8 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг, засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэхээр заасан боловч Төрийн хэмнэлтийн хуулиар дээрх арга хэмжээний зардлыг хориглосон байна.

0702000083

Тайлант онд 245.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 104 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 83.2 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	134,615.0	140,904.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	984,393.7	1,165,519.2
	Нийт хөрөнгийн дүн	1,119,008.7	1,306,423.7
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,119,008.7	1,306,423.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,119,008.7	1,306,423.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	538,679.11	710,348.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	499,150.87	524,074.6
	Үйл ажиллагааны үр дүн	39,528.2	186,273.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	82,500.00	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-42,971.8	186,273.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,079,562.98	1,120,150.1
	Тайлант оны үр дүн	39,445.73	186,273.6
	Эцсийн үлдэгдэл	1,119,008.7	1,306,423.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	417,806.09	480,146.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	407,826.09	455,147.2
	Үйл ажиллагааны ЦМГ	9,980.0	24,999.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-9,980.0	-24,999.4
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	357,361.0	444,872.8
	Урсгал зардал	347,381.0	419,873.4
	Хөрөнгийн зардал	9,980.0	24,999.4
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	357,361.0	444,872.8
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	357,361.0	444,872.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 87.1 сая төгрөгийн алдаа¹ зөрчлийг арилгасан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- ✓ Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг 87.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 137.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 16.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 11 заалт албан шаардлага, 2 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 0.4 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Цалингийн зардлаас 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт, түлш халаалтын зардлаас 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт, нийт 2.6 сая төгрөгийг төлж төсөв хохироосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Сумын Засаг даргад цалингийн сангаас 0.3 сая төгрөгийн тосгоны нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.Төрийн албан хаагчийн цалин хөлс нь: "57.2.1.улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажилчдын аялал зугаалгын зардалд нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 1.0 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дугаар

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 4.2.6.үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс хүндэтгэл үзүүлэх 4.2 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйлд 2.7 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 5.4.-т " бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажлаас чөлөөлөгдсөн Засаг даргын орлогчид 5.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-т "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.2 сая төгрөгийг Засаг даргын захирамжаас илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Сумын Засаг даргын 2022 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн А/98 дугаар захирамжийг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 1.3 сая төгрөг олгож төсөвт хохирол учруулсан нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар

- төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Аймгийн засаг даргын баталсан бүтэц орон тоогоор нярав үйлчлэгч 1 орон тоогоор байхад тус бүр нэг орон тоогоор ажиллуулж 6.5 сая төгрөгийн цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн А/630 дугаар захирамжийн заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
 - ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс сайн малчны шагнал арга хэмжээнд 2.9 сая төгрөг, тэмцээнд оролцох зардалд дэмжлэг 2.9 сая төгрөг, малчдын зөвлөгөөний үйл ажиллагаанд 3.6 сая төгрөг, сумын алдартны шагналд 1.4 сая төгрөг, эмчилгээний зардалд дэмжлэг 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 5.4.-т " бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
 - ✓ Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 48.4 сая төгрөгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүй зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна." заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
 - ✓ Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн зардлаас худгийн гэрээт ажилтны урамшуулалд 1.7 сая төгрөг, түлш халаалтын зардлаас шүлхийн постны нүүрсний үнэ 0.5 сая төгрөгийг тус бүр зардлын зүйл анги зөрчиж гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
 - ✓ Худгийн 2 ажилтанд 4.3 сая төгрөгийн цалин урамшууллыг гэрээ байгуулалгүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан

шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Гэрээний хугацаа дууссан байхад 74.9 сая төгрөгийн 465 толгой малыг дараагийн айл өрхөд шилжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", Хоорондын байгуулсан гэрээний 1.4-т "түрээсийн эргэн төлөлтийн хугацаа буюу 2022 оны 8 дугаар сард талууд гэрээгээ дүгнэн сумын Засаг даргын тамгын газраас комисс ажиллаж акт үйлдэнэ" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч тоолуур ашигладаггүй, талбайн хэмжээгээр халаалтын төлбөр хийдэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний 19.1 сая төгрөгийг И баримтгүй гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш 22 орлого, зарлагын гүйлгээнээс 20 мэдээллийг мэдээлээгүй, 9 тушаал шийдвэрээс 1 тушаалыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Өмнөх аудитын 76.6 сая төгрөгийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй үлдэгдэлтэй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн

бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

- ✓ Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмадын хорооны урамшуулалд 1.2 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэлгэр сумын Засаг даргын тамгын газар	6	87.14	2	17.67	4.00	69.46	6	87.14				
Дүн	6	87.14	2	17.67	4	69.46	6	87.14				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага		Хууль,	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цээл сумын Засаг даргын тамгын газар	16	118.83	7	16.61	8	101.01	1	1.20	-	-	-	-
Дүн	16	118.83	7	16.61	8	101.01	1	1.20	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг дутуу мэдээллэсэн	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	0	-	-	1	-	-	-
Бусад хуль тогтоомжтой холбоотой зөрчил								
Автотээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дулааны тоолуур ашиглаагүй	1	-	-	-	1	-	-	-
И баримтгүй гүйлгээ хийсэн	1	19,143.0	-	-	1.0	19,143.0	-	-
Дүн	3	19,143.0	-	-	2.0	19,143.0	1	-
Нийт дүн	4	19,143.0	-	-	3.0	19,143.0	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		